ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**Аудитын код:** ХОА-2022/30/НА/-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Ховд хот<br>2022 он | Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn<br>Аудитор: У.Батчимэг<br>Утас: 70432545<br>цахим хаяг:batchimeg.urt@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.08 № 2/07

танай ____________-ны № ____________-т

АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Х.БАТЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

2021/A-4 ba

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.08 № 2/07

танай ______________-ны №______________-т

АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Х.БАТЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.08 № 2/07

танай ____________-ны №____________-т

АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Х.БАТЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Татварын хэлтсийн 2021оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН

2021/A-4 ba

8417143692
ПЮА0073 9066454

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....... 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....... 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....... 3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....... 4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....... 5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....... 5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ....... 7
3. Аудитын тайлан ....... 7
3.1 Ерөнхий зүйл ....... 7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....... 8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....... 8
3.4 Материаллаг байдал ....... 8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....... 9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....... 9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....... 10
3.8 Аудитын гол асуудал ....... 10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....... 10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....... 10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....... 10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....... 10
4. Аудитын илрүүлэлт ....... 11
4.1 Залруулсан алдаа ....... 11
4.2 Зөвлөмж ....... 11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....... 12

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БОАЖЯ | Байгаль орчин аялал жуулчлалын яам |
| ДБХС | Дэлхийн байгаль хамгаалах сан |

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **60,298,076.93** | **88,875,121.93** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 60,298,076.93 | 88,875,121.93 |
| **354** | **Хангамжийн материал** | 60,298,076.93 | 88,875,121.93 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,098,245 | 5,140,640.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | 2,600,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 1,550.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 58,199,831.93 | 81,132,931.93 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,580,477,452.42** | **1,492,608,603.35** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,580,477,452.42 | 1,492,608,603.35 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,546,598,452.42 | 1,458,729,603.35 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,392,429,000.00 | 1,392,429,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 74,997,644.00 | 110,185,998.25 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 115,000,000.00 | 115,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 37,773,720.00 | 56,922,897.50 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 196,617,698.76 | 228,086,938.76 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | 62,822,213.66 | 125,769,083.84 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 17,877,100.00 | 17,877,100.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | 5,872,386.78 | 7,772,327.60 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 130,567,700.00 | 130,567,700.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | 124,427,081.90 | 124,580,828.22 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 33,879,000.00 | 33,879,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 33,879,000.00 | 33,879,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,640,775,529.35** | **1,581,483,725.28** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,640,777,079.35** | **1,581,483,725.28** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,640,777,079.35 | 1,581,483,725.28 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 356,656,848.00 | 356,656,848.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 356,656,848.00 | 356,656,848.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,273,011,896.06 | 1,213,718,541.99 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,172,125,623.01 | 1,273,011,896.06 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 100,886,273.05 | (59,293,354.07) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 11,108,335.29 | 11,108,335.29 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,640,777,079.35** | **1,581,483,725.28** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,135,238,603.69** | **1,046,788,540.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **196,366,145.69** | **46,875,740.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 196,366,145.69 | 46,875,740.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 46,875,740.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **938,872,458.00** | **999,912,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 938,872,458.00 | 999,912,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 918,872,458.00 | 998,412,800.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 20,000,000.00 | 1,500,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,034,352,330.64** | **1,106,081,894.07** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,034,352,330.64** | **1,106,081,894.07** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 987,224,772.64 | 1,102,081,894.07 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 654,755,700.00 | **742,360,800.00** |
| 210101 | Үндсэн цалин | 418,144,696.00 | 451,863,323.35 |
| 210102 | Нэмэгдэл | 150,653,004.00 | 111,444,076.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 19,008,000.00 | 97,988,185.65 |
| 210104 | Урамшуулал | 66,950,000.00 | 81,065,215.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **88,392,000.00** | **100,197,700.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,741,817.00 | 69,467,556.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,473,168.00 | 8,113,645.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,757,240.00 | 5,945,893.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,408,539.00 | 1,486,477.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,011,236.00 | 15,184,129.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **50,293,900.00** | **49,788,800.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,645,978.00 | 3,257,569.00 |
| 210302 | Түлш, халаалт | 42,151,457.00 | 42,151,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,496,465.00 | 4,379,831.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **28,544,016.00** | **24,095,905.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,911,505.00 | 6,516,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,827,957.49 | 7,742,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,751,400.00 | 3,562,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 333,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 179,700.00 | 1,160,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,749,353.51 | 4,781,005.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,920,000.00 | **5,692,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,920,000.00 | 5,692,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 41,228,800.00 | **55,068,600.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 39,896,000.00 | 51,982,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 896,000.00 | 896,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 136,900.00 | 102,400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл технологи үйлчилгээ | | 1,990,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 149,900.00 | 76,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **119,090,356.64** | **124,878,089.07** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,548,000.00 | 5,540,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 111,381,356.64 | 119,338,089.07 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **47,127,558.00** | **4,000,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **41,895,558.00** | **4,000,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,119,958.00 | 4,000,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **100,886,273.05** | **(59,293,354.07)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 356,656,848.00 | 11,108,335.29 | 1,172,125,623.01 | 1,539,890,806.30 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **356,656,848.00** | **11,108,335.29** | **1,172,125,623.01** | 1,539,890,806.30 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 100,886,273.05 | 100,886,273.05 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **356,656,848.00** | **11,108,335.29** | **1,273,011,896.06** | 1,640,777,079.35 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **356,656,848.00** | **11,108,335.29** | **1,273,011,896.06** | 1,640,777,079.35 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **356,656,848.00** | **11,108,335.29** | **1,273,011,896.06** | 1,640,777,079.35 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (59,293,354.07) | (59,293,354.07) |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **356,656,848.00** | **11,108,335.29** | **1,213,718,541.99** | 1,581,483,725.28 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **939,052,124** | **999,912,800** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **939,020,124** | **999,912,800** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 938,872,458 | 999,912,800 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 918,872,458 | 998,412,800 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 20,000,000 | 1,500,000 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **939,052,124** | **996,337,800** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **939,052,124** | **996,337,800** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **891,776,900** | **992,337,800** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 654,755,700 | 742,360,800 |
| 210101 | Үндсэн цалин | 418,144,696 | 422,018,288 |
| 210102 | Нэмэгдэл | 150,653,004 | 153,735,919 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 19,008,000 | 71,362,093 |
| 210104 | Урамшуулал | 66,950,000 | 95,244,500 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 88,392,000 | 100,197,700 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,049,200 | 70,503,300 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,835,700 | 7,423,600 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,468,600 | 5,938,900 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,367,100 | 1,484,700 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,671,400 | 14,847,200 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 50,593,900 | 49,788,800 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,645,978 | 3,078,692 |
| 210302 | Түлш, халаалт | 42,151,457 | 42,151,400 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,796,465 | 4,558,708 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,172,500 | 26,814,900 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,911,505 | 6,516,000 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,821,400 | 7,742,000 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,751,400 | 3,562,200 |
| 210404 | Ном, хэвлэл | 124,100 | 333,800 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 179,700 | 1,160,900 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,384,395 | 7,500,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **11,230,000** | **3,400,000** |
| 210604 | Урсгал засвар | 1,230,000 | 3,400,000 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,920,000 | 5,692,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,920,000 | 5,692,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 41,228,800 | 59,378,600 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 39,896,000 | 53,282,100 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 896,000 | 896,000 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 102,400 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 136,900 | 22,000 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 5,000,000 |
| 210807 | Газрын төлбөр | 149,900 | 76,100 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16,484,000 | 4,705,000 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,524,000 | 4,705,000 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **47,275,224** | **4,772,339** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 42,043,224 | 4,772,339 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 147,666 | 772,339 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,119,958 | 4,000,000 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | - | **3,575,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | - | **3,575,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **3,575,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 3,575,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 3,575,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | - | **(3,575,000.00)** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны Батлагдсан төлөвлөгөө | Тайлант оны Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 998,412,800 | 998,412,800 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 998,412,800 | 998,412,800 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 994,412,800 | 994,412,800 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 742,360,800 | 742,360,800 |
| 210101 | Үндсэн цалин | 441,912,700 | 422,018,288 |
| 210102 | Нэмэгдэл | 134,055,600 | 153,735,919 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 71,148,000 | 71,362,093 |
| 210104 | Урамшуулал | 95,244,500 | 95,244,500 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 100,197,700 | 100,197,700 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 70,503,300 | 70,503,300 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,423,600 | 7,423,600 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,938,900 | 5,938,900 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,484,700 | 1,484,700 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,847,200 | 14,847,200 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 49,788,800 | 49,788,800 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,247,400 | 3,078,692 |
| 210302 | Түлш, халаалт | 42,151,400 | 42,151,400 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,390,000 | 4,558,708 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **26,814,900** | **26,814,900** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,516,000 | 6,516,000 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,742,000 | 7,742,000 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,562,200 | 3,562,200 |
| 210404 | Ном, хэвлэл | 333,800 | 333,800 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,160,900 | 1,160,900 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,500,000 | 7,500,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,400,000** | **4,400,000** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,000,000 | 1,000,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 3,400,000 | 3,400,000 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,692,000 | 5,692,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,692,000 | 5,692,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **59,378,600** | **59,378,600** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 53,282,100 | 53,282,100 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 896,000 | 896,000 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 102,400 | 102,400 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000 | 22,000 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,000,000 | 5,000,000 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000 | 22,000 |
| 210806 | Мэдээлэл технологи үйлчилгээ | 5,000,000 | 5,000,000 |
| 210807 | Газрын төлбөр | 76,100 | 76,100 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,780,000** | **5,780,000** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,780,000 | 5,780,000 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,000,000** | **4,000,000** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **4,000,000** | **4,000,000** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,000,000 | 4,000,000 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **998,412,800** | **998,412,800** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **998,412,800** | **998,412,800** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 998,412,800 | 998,412,800 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 49 | 51 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 43 | 44 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 4 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **48** | **51** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 43 | 46 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 5 | 5 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх он** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **20,000,000** | **1,500,000** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **20,000,000** | **1,500,000** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 10,000,000 | 1,500,000 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | | 1,500,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,000,000 | |
| 210602 | Тавилга | 10,000,000 | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэл дадлага хийх | | 1,500,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,000,000 | |
| **213** | **Урсгал шилжүүлэг** | 10,000,000 | |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 10,000,000 | |
| 213204 | Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 10,000,000 | |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 20,000,000 | 1,500,000 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 20,000,000 | 1,500,000 |
| 131103 | ЗГНХ ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц | 20,000,000 | 1,500,000 |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хэмнэлтийн тогтоолыг мөрдөх талаар зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор У.Батчимэг 2022 оны 01 дүгээр сарын 28-наас 2022 оны 02 дугаар сарын 07–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 21 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн Татварын хэлтэс нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр хангаж зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, улс, орон нутгийн төсвийн татварын орлого бүрдүүлэх, төрийн захиргааны удирдлагаар хангах, хүний нөөц, төсөв санхүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх талаар дараах тогтоолд өөрчлөлт ороогүй байна.

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 1106081.8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 22.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн

материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 17.6 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Татварын хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 59,293.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 60,299.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл нь 88,875.12 мянган төгрөг 28,575.5 мянган төгрөгөөр буюу 47 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 38,666.7 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 20,817.6 мянган төгрөгөөр ажлын хувцас, ажлын үнэмлэх, арьсан гэр, нийт 59,484,3 мянган төгрөгөөр бараа материалын данс нэмэгдэж, 30,908.8 мянган төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1,580,477.4 мянган төгрөг байсан бол оны эцэст 1,492,608.6 мянган төгрөг болж 87,868.8 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдэлтэй холбоотой байна .

Тайлант онд 27,894.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан, акталж устгасан хөрөнгөгүй ба тайлант оны эцэст 1,458,729.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 1539,890,8 мянган төгрөг байсан оны эцэст 1,581,483,7 мянган төгрөг тайлант онд 59,293.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 59,293.3 мянган төгрөгийн алдагдал нөлөөлсөн байна.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 998,412.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 998,412.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Татварын ерөнхий газраас тус байгууллагын төсвийг 998,412.8 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 998,412.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 998,412.8 мянган төгрөгийг улсын төсвөөс зардалд санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 998,412.8 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар аймгийн Засаг даргын тамгын газраас татвар төлөгчдийн өдөрлөгт зориулан 1500.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс 150 хугацаандаа оруулсан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 12, зарлагын 7 гүйлгээ гарсныг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан боловч 1,2,7 дугаар саруудын мэдээллийг хоосон байршуулан илгээсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 8734.9 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын бүртгэлд байгаа 2.4 сая өртөгтэй орон сууцны асуудлыг дараагийн аудитаар хянан үзэх шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,739.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7770.0 мянган төгрөгийн алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, эдийн засгийн ангилал зөрүүтэй бүртгэсэн тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, Шилэн дансны мэдээллийг баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд мэдээлэл технологийн зардлаар тайлагнах 5,000.0 мянган төгрөгийн зардлыг бичиг хэргийн зардлын ангилалд буруу ангилан бүртгэсэн.,
2. Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлаар тайлагнах 2,770.0 мянган төгрөгийг НДШ-ийн ангилалд буруу ангилан бүртгэсэн байна.
3. Шилэн дансны 1,2,7 дугаар саруудын хоосон илгээсэн мэдээллүүдийг аудитын явцад бүрэн байршуулсан.

***Шийдвэрлэсэн нь:*** Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 7,770.0 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоотыг тухайн байгууллага ирүүлсэн болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### *4.4.1 Дотоод хяналттай холбоотой асуудал*

Илрүүлэлт: Татварын хэлтсийн хуучин Конторын барилга нь 1953 онд ашиглалтад орсон цаашид ашиглах боломжгүй талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарч хөрөнгө оруулалтаар шинэ барилга барьж, 2019 онд ашиглалтад оруулснаар сүүлийн 2 жил харуул хамгаалалтын зардал төлж, байр ашиглалтгүй байна. Тус байрны харуул хамгаалалтын зардалд 2021 онд 1,800.0 мянган төгрөгийн зардал гарсан байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид ашиглах боломжгүй болсон хуучин конторын барилгыг холбогдох дээд шатны газарт уламжлан шийдвэрлүүлэн ажиллах.

#### *4.4.2 Төсвийн зарцуулалт*

Илрүүлэлт: 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн 47 дугаар тогтоолоор албан тушаалтны гар утасны төлбөрийг төсвөөс санхүүжүүлэхгүй байх гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүйтэй холбоотой 568.9 мянган төгрөгийг байгууллагын удирдлагын гар утасны төлбөрт зарцуулсан зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Албан тушаалтны гар утасны төлбөрийг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн төлөхгүй Засгийн газрыг тогтоол шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах, цаашид гар утасны төлбөрийг төсвийн хөрөнгөөр төлөхгүй таслан зогсоох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Татварын хэлтэс | 5 | 10738.9 | 3 | 7,770.0 | | | 0 | 0 | 2 | 2968.9 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН

АУДИТОР: У.БАТЧИМЭГ